

Дээрх баримтуудыг няглан дүгнэвээс бидний өвег дээдэс хүртэл харь улсын хэлийг чухалчлан үзж эл талын мэдлэг боловсролтой хумуусийг сургаж бэлтгэж байсан баялаг туршлагатай ажээ. Иймд Монголын гадаад хэлний сургалт бол эртний түүхтэй агаад наанадаж дундад зүн цаанадаж хүннүүгийн үеэс эхпэн тооцогдох ёстой ажээ.

хүртэл харь улсын хэлийг чухалчлан үзж эл талын мэдлэг боловсролтой хумуусийг сургаж бэлтгэж байсан баялаг туршлагатай ажээ. Иймд Монголын гадаад хэлний сургалт бол эртний түүхтэй агаад наанадаж дундад зүн цаанадаж хүннүүгийн үеэс эхпэн тооцогдох ёстой ажээ.

## АЛТАН АРГАМЖ

ALTAN ARGAMJ

VOL.3

1/2000

### БОЛЗМОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ

муис, оуухс-ийн базш  
С.Сүхээ

Шинжлэх ухаан техникийн үсрэнгүй хөгжлийн эрин үед нийгмийн хэл шинжлэлийн гүйцэтгэх ширэг улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай болж байна. Үүний нэг тоджишээ бол эрдэмтэд хэлийг хүн төрөлхтөний гагцхуу харилцааны хэрэггүүр биш харин аливаа нэг улс орны хөгжил, түүний ард олны оюуны болон техникийн үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгох арга хэрэгслэл болгон авч үзж байгаад оршино.

ХХ зууны 70-аад оноос эхэлж улмаар 80-аад онуудад эрч хүчээс авч байгаа манай гаригийн ихэнх орныг хамарсан нийгмийн дунд хурдацтай дэлгэрч буй зохиомол (болзмол) хэл нийгмийн хэл шинжлэлийг тойрон гарсангүй. Энэ бүгд нь нийгэм хэл хоёрын харилцан уялдаа холбоог зайшигүй судлан үзэх нийгмийн хэл шинжлэлийн хойшлуулшгүй гол асуудлын нэг болон гарч ирэв. Нийгмийн хэл шинжлэлийн нэг салшгүй салбар нь нийгмийн аялгуут хэл бөгөөд тунд хамарагдах зохиомол хэл бол нь олон орны эрдэмтдийн анхаарлын гадуур өнгөрөх ёсгүй харуулах болжээ. Гаж буруу уг хэллэгээс (англиар-спэнг, оросоор благ буюу феня г.м.) бүтгэг этгээд хэлийг манай хойд хөрш орны эрдэмтэд хэдийнээ судалж ирсэн хэдий ч эрчимтэй судалгааг 1980-аад оны дунд үеэс эхэлсэн билээ. Манай орны хувьд нийгмийн хэл шинжлэлийн энэ салбарг т цагдаагийн дээд

сургуулийн хууль зүйн ангид гэмт хэрэгтнүүдийн этгээд уг хэллэг (жаргон)-ийг үздэгээс гадна манай улсын тусгай албаны хэрэгцээнд зориулсан 200 орчим уг хэллэгтэй жижиг тайлбар толь хэвлэн гаргаж байсныг эс тооцвол дорвitoj хийсэн судалгаанаас узехэд гэмт хэрэгтэй ба нийгмийн доторхи гаж буруу ёс суртахуунтай хэсэг бүлэг хүмүүсийн хороондох харилцаанаас үүссэн хоёр мянга гаруй уг хэллэг Монгол хэлэнд энэхүү зохиомол (болзмол) хэлийг бий болгож байна.

Этгээд хэл нь жинхэнэ зохиомол (болзмол) хэл бөгөөд түүнийг францын нэрт зохиолч В.Гюгогийн хэлснээр нийгмийн харш бүлэг болох жинхэнэ хулгайч нарын (араа, аргатам) хэл юм. Учир нь эл уг хэллэг ял эдэлж гарсан этгээдүүдийн ярианы хүрээнээс хальж орчин цагийн ярианы хэлэнд нэвтрэх нэн ялангуяа запуучуудын бараг одор түмэн хэрэглээ болон хувирчээ. Гэмт хэрэгтний этгээд уг хэллэгүүд нь эхлээд цеен хүний хүрээнд хэрэглэгдэж байснаа хожим нийтийн хүртээл болох хэм хэмжээнд ордог байна. Энэ нийгэм, олон түмэнд соёлжих боловсроход хөнөөл учруулаад зогсохгүй бур эсрэг үр дагавартай байдаг. Учир нь эл уг хэллэг өөрийн хүрээнээс хальж нийтэд нэвтрэхдээ гол төлөв хүмүүжил, ухамсарын төвшин дорой запуучуудын сагсуурах, гайхуулах, тэр ч буу хэл олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, айлан сурдуулэх хэл болдог байна.

Манай улсын гэмт хэрэгтнүүдийн этгээд уг хэллэгүүдийг хэрэглэгч хүмүүсийн байдлаар нь авч узехэд:

1. чөлөөтэй явваа гэмт хэрэгтнүүдийн этгээд уг хэллэг
2. мөрдөнд байгаа хэрэгтнүүдийн хэллэг
3. ял эдэлж байгаа ялангуудын хэллэг
4. хулгайч нарын хэллэг
5. биеэ үнэлэгч хөнгөн явдалт эмсийн уг хэллэг
6. архичдын уг хэллэг
7. мөрийтэй тогтолгчдын хэллэг

8. хар захын дамчдын хэллэг гэх зэрэгээр ангилж болох юм.  
Гэвч энэ антипап болзмол шинжтэй юм, учир нь дээрх уг хэллэгүүд нь нэгээс негеедее шилжих явдал өргөн дэлгэр бий.

Этгээд гаж уг хэллэгийг аливаа нэг улс орон, ард түмэн хэрэгтэхийг эртнээс ихэд цээрлэн иржээ. Үүний нэг тод жишээ бол: Их эзэн Чингис хаан түмтийн жанжинг зохиистгүй хуралд өөрийн нэг жанжинг бүдүүлгээр ярилаа гэж хөөн гаргаж фельдмаршал цоплыг эргүүлэн хураан авч байжээ. Францын император нэгдүгээр Наполеон Бонапарт хээрийн хуралд өөрийн нэг жанжинг бүдүүлгээр ярилаа гэж хөөн гаргаж фельдмаршал цоплыг эргүүлэн хураан авч байжээ. Орос оронд нэгдүгээр Петр хаан хараалын уг хэлсэн хүнд 5 кг жинтэй тухай (медаль) бүр сарын хугацаатай хүзүүнээс нь зүүж залхаадаг байжээ. Гэвч уг тухайг зүүсэн хүн 2-3 хоногоос илүү даан явж чаддагчийг байжээ. Ийнхүү хүн төрөлхтөн гаж буруу, этгээд уг хэлнээс ариун сайхан үндэснийхээ хэлийг цэвэрлэж байжээ. Харамсалтай нь олон оронд үзүүнгөөсөн тайчих урлаг (стрептиз шоу), эрэмийн харьцааг өргөн дэлгэр сурталчилсан сонин хэвлэл, порно кино, биеэ үнэлэгчдийн цэцэрлэг, арьс өнгөний өвчин, зодоон, архидалтын үүр болсон пивоны бар зэрэг амьдралтын эрээн бараан газрууд манайд борооны дараах меөг шиг олонор бий болж байгааг манай хууль хяналт, цагдаагийн удирдах байгууллагын ноёдууд, олон түмэн, эрдэмтэн мэргэдийн анхаарах цаг нэгэнт болжээ.